



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/134

Улаанбаатар хот

“Сахилга хариуцлагыг бүх шатанд
дээшлүүлж, бүтээн байгуулалтыг өрнүүлэн,
эко ногоон орчинг нэмэгдүүлэх” жил
зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд 2018 оныг сахилга хариуцлагыг бүх шатанд дээшлүүлж, бүтээн байгуулалтыг өрнүүлэн эко ногоон орчинг нэмэгдүүлэх жил болгон зарласугай.

2. Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж, нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж, биелэлтийн явцыг хагас, бүтэн жилээр хуралд танилцуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Эрх зүй төрийн байгуулалтын ажлын хороо /Б.Мягмарсүрэн/-д үүрэг болгосугай.



Б.МӨНХЦЭЦЭГ